



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 5/09

Чингис хот

**Б.Мөнхжаргалыг ахлах
мэргэжилтнээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж тус газрын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05/509 тоот албан бичгээр ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Бөхчулууны Мөнхжаргалыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтнээр 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Мөнхжаргалын цалинг ТЗ-6-4 шатлалаар тогтоон, үндсэн цалинг 813215 /найман зуун арван гурван мянга хоёр зуун арван тав/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Г.Ариунхүү/-д зөвшөөрсүгэй.

3. Б.Мөнхжаргалд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030026